

Тайваний засгийн газрын тэтгэлэг 2019

Монголын ард түмний Тайванийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хоёр талын боловсролын салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэхийн тулд Тайванийн Боловсролын яамнаас 2019 оны хичээлийн жилд Монгол Улсаас 11 оюутан залууст олгохоор шийдвэрлэсэн тэтгэлгийн удирдамжтай танилцана уу

Нэг. Тэтгэлэг

Үүнд бакалавр, магистр, докторт суралцагсад доорхи тэтгэлгийг олгоно.

1. Сургалтын төлбөр болон бусад зардал. (Сургалтын улирлын төлбөр болон сургалтын бусад зардалын төлбөр багтана) Тэтгэлэгт 40000 тайвань долларыг(цаашид NTD гэх) Тайванийн засгийн газраас олгох ба тэтгэлгээс гадна нэмэгдэл төлбөр гарсан тохиолдолд болон бусад зардалд бичиг баримтын бүрдүүлэлтийн зардал, илтгэл, даатгал, байр, интернетийн төлбөр зэргийг суралцагч өөрөө хариуцах болно.
2. Амьжиргааны зардал. Бакалаврын оюутанд сар бүр 15000 NTD, магистр докторт суралцагсад сар бүр 20000 NTD тэтгэлэг олгох болно.

Хоёр. Тэтгэлгийн хугацаа

Суралцагсад бакалаврт 4 жил, магистрт 2 жил, докторт 4 жилийн хугацаанд тэтгэлэгт хамрагдах боломжтой. Тус тэтгэлэгийг нийт 5 жил хугацаанд эдлэх эрхтэй. Тайваньд суралцуулах тэтгэлэг нь жил бүрийн 9-р сарын 1-ний өдрөөс дараа оны 8-р сарын 31-ний өдөр хүртэл үргэлжилнэ. Тэтгэлэгт хамрагдагсад нь тухайн сургуулийн бүртгэлийн хугацаанд бүртгэл хийлгэсэн байх шаардлагатай бөгөөд бүртгэл хийгдээгүй болон сургуульдаа тэнцээгүй тохиолдолд тэтгэлэг олгох боломжгүй болно. Тухайн сургууль болон боловсролын яамнаас бүртгүүлэх хугацааны сунгалт хийгдсэн тохиолдолд дээрхи шаардлага хамаарахгүй болно.

Тэтгэлгээр суралцах оюутан сургуульдаа бүртгүүлээд хичээл эхэлсэн сараас эхлэн тэтгэлгийн хугацаа дуустал буюу тухайн оюутан сургуулиа төгсөх, чөлөө авах, сурахаа болих хүртэлх тэтгэлгийг олгоно.

Гурав.Тавигдах шаардлага

1. Бүрэн дунд болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй, онц сайн дүнтэй төгссөн, сахилга бат сайтай байх
2. Доорхи нөхцөлд бүртгүүлэх боломжгүй

-Цагаач иргэн, Тайванийн иргэн

-Тайванийн их дээд сургуульд элссэн, суралцаж буй болон бусад төрлийн тэтгэлэгт хамрагдсан (төгсөх ангийн оюутан эрдмийн зэрэг ахиулан суралцахаар хүсэлт гаргаж буй тохиолдолд энэ заалтанд хамаарагдахгүй)

-Тайваньд боловсролын ижил зэргээр суралцаж байсан.

-Тайванийн их, дээд сургууль ба гадаадын их, дээд сургуулийн хоорондын боловсролын хамтын ажиллагааны гэрээний шугамаар суралцаж байсан.

-Урьд нь тус тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж байсан оюутны тэтгэлэг авсан

нийт хугацаа нь таван жилээс хэтэрсэн байх.

-Урьд нь тус тэтгэлэгт хөтөлбөрт болон Тайванийн Боловсролын Яамны Хятад хэлний тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаад тэтгэлэг авах эрхээ хасуулсан оюутан байх

-Тайваньд суралцаж байх хугацаандаа Тайванийн төрийн байгууллагууд болон сургуулиудын тэтгэлэгт хамрагдсан байх. Харин уг тэтгэлэгт хамрагдсан боловч сургалтын төлбөрт хүрэлцэхгүй тохиолдолд тухайн сургуулиас сургалтын төлбөрийг зөрүүг төлүүлсэн байж болно.

3.Тайванийн тэтгэлэгт өргөдөл гаргагч нь өөрийн сонгосон их дээд сургуулиудад тухайн сургуулийн журмын дагуу бүртгэлийн хугацаанд бүртгүүлсэн байх шаардлагатай бөгөөд сургуульд бүртгүүлсэн өргөдөлийн маягтын хуулбарыг тус төлөөлөгчийн газарт хүлээлгэн өгнө. Мөн тус төлөөлөгчийн газарт хүргэгдсэн бичиг баримт буцаан олгогдохгүй.

Дөрөв. Бүрдүүлэх материал

1. Тайваньд суралцах тэтгэлгийн өргөдлийн маягт **SCHOLARSHIP-APPLICATION-FORM1**
2. Паспортын хуулбар эсвэл тэтгэлэг хүсэгчийг гадаадын иргэн болохыг нотлох бичиг баримт
3. Боловсролын гэрчилгээ болон дүнгийн жагсаалтын Тайванийн төлөөлөгчийн газраар баталгаажуулсан хуулбар.
4. Тайванийн их, дээд сургуульд элсэн суралцах өргөдлийн маягтын хуулбар (Жишээ нь: Сургуулийн бүртгэлийн хураамжын баримт, элсэлтийн хуудсын хуулбарууд, тухайн сургуулиас ирүүлсэн хариу захидал)
5. Тэтгэлэг хүсэгчийн хэлний түвшинг гэрчлэх бичиг баримтын хуулбар

Хятад хэлээр суралцах бол

Хятад хэлний түвшин тогтоох шалгалт HSK 5 (TOCFL Level5) эсвэл бусад хятад хэлний түвшин тогтоох шалгалтын гэрчилгээ

Англи хэлээр суралцах бол

Бакалаврын элсэгч англи хэлний түвшин тогтоох шалгалтын

IBT TOEFL 68-с дээш оноо

ITP TOEFL 520-с дээш оноо

IELTS 5.5-с дээш оноо авсан гэрчилгээ

Магистрын зэрэгт элсэгч англи хэлний түвшин тогтоох шалгалтын

IBT TOEFL 76-с дээш оноо

ITP TOEFL 540-с дээш оноо

IELTS 5.5-с дээш оноо авсан гэрчилгээ

Докторын зэрэгт элсэгч англи хэлний түвшин тогтоох шалгалтын

IBT TOEFL 79-с дээш оноо

ITP TOEFL 550-с дээш оноо

IELTS 6-с дээш оноо авсан гэрчилгээ

6. Сургуулийн захирал болон доктор эрдмийн зэрэгтний 2 хувь тодорхойлолт

Тав. Материал хүлээн авах газар

Тайпэйн худалдаа, эдийн засгийн төлөөлөгчийн газар ш/х 1269, Улаанбаатар-13, Монгол улс

Утас: 976-11-322735 Факс: 976-11-322916

Зургаа. Материал хүлээн авах эцсийн хугацаа

Материалыг 2019 оны 4-р сарын 20-ны дотор бүрдүүлж өгнө.

Долоо. Ярилцлаганд орох хугацаа : 2019 оны 5 сарын 7, 8-ны өдөр (ярилцлагын хугацаа өөрчлөгдсөн тухай бүрт мэдэгдэнэ)

Найм. Тус төлөөлөгчийн газар нь 2019 оны 5-р сарын эцсээр тэтгэлэгт урьдчилсан байдлаар тэнцсэн хүмүүсийн нэрсийг зарлана.

Ес. Урьдчилсан байдлаар тэтгэлэгт тэнцсэн оюутны нэрсийг 2019 оны 6-р сарын 30-аас өмнө Тайванийн их, дээд сургуулиудаас тухайн оюутанг элсүүлэн авсан эсэх талаарх хариугаа хүлээн авсан байх ба Тайванийн их, дээд сургуульд элсэн суралцах эрхийн бичгийн хуулбараа тус төлөөлөгчийн газар хүлээлгэн өгснөөр тэтгэлэг авах эрх баталгаажих болно.

Арав.

Урьдчилсан байдлаар тэтгэлэгт тэнцэгч нь 2019 оны 6-р сарын 30-аас өмнө Тайванийн их, дээд сургуулиудаас тухайн оюутанг элсүүлэн авсан эсэх талаарх хариугаа хүлээн авсан байх ба Тайванийн их, дээд сургуульд элсэн суралцах эрхийн бичгийн хуулбараа тус төлөөлөгчийн газар хүлээлгэн өгснөөр тэтгэлэг баталгаажих болно. Тус төлөөлөгчийн газар нь 2019 оны 8-р сард Тайванийн тэтгэлэг авах болзол хангасан оюутнуудыг хүлээн авч, Тайванийн талаар товч мэдээлэл өгнө.